

Living the LOTUS

Buddhism in Everyday Life



Үүсгэн байгуулагчийн сургаал

Нэг мөч, нэг учрал

Шагжамүни бурханы амьдарч байсан тухайн үеийн Энэтхэгт Коосала хэмээх том гүрэн байжээ. Тэр улсын хаан нэгэн удаа “Яаж ч толгойгоо гашилтал бодсон өөрөөс минь өөр хайрламаар хүн алга. Та юу гэж бодож байна?” хэмээн гүнжээсээ асуутал, гүнж ч бас бодоод үзэхэд үнэхээр л би өөртөө л хамгийн хайртай юм байна хэмээн хариулжээ.

Тэгээд Шагжамүни бурханаас асууж үзэхээр болов. Тэр хаан болон хааны гүнжид Шагжамүни бурхан бээр: “Өөрийгөө хамгийн их хайрладаг гэдгээ мэдсэн бол бусад хүн ч гэсэн өөртөө хамгийн их хайртай болохыг ойлгох биз ээ. Тиймээс бусдыг хохироож үл

болно.” хэмээн сургажээ.

Бид магадгүй зөвхөн өөрийнхөө байр сууринаас аливаад ханддаг. Тийм үедээ түр өөрийгөө хойш нь тавиад, нөгөө хүнийхээ оронд өөрийгөө тавиад үзээрэй. Нөгөө хүнийхээ оронд бодож үзээрэй. Тэгвэл тухайн зүйл огт өөрөөр харагдах болно. Нүднээс өргөс авсан мэт л нөгөө хүний зүрх сэтгэл, юмсын үнэн дүр төрх харагдах болно.

Бусдын оронд өөрийгөө тавьж, өөр өнцгөөс харж чаддаг болохыг “Нигүүлсэнгүй нүдээр хардаг болох” гэж хэлнэ.

Үүсгэн байгуулагчийн үг 9» X274-275

Living the Lotus Vol. 182 (2020.11)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

TEL: +81-3-5341-1124

FAX: +81-3-5341-1224

Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp


Ахлах редактор: Саитоо Коочироо

Орчуулсан: Ж.Сэлэнгэ, Ж.Гэрэлтуяа

Эхийг хянасан: Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.



“Талархаад баршгүй” гэж хэлж чадахын аз жаргал

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо

Даган баясах сэтгэл

Цагаан Лянхуа Судрын “Даган баясахуйн эрдэм буяныг өгүүлэх бүлэг”-т сургаалыг сонсоод, үнэн сэтгэлээсээ баярлан талархаж, тэрхүү баяр хөөрөө бусдад дамжуулахын ач буяныг айлдсан. Сургаалыг сонсоод, үнэн сэтгэлээсээ “Сургаалтай учирсандаа талархаад баршгүй.” хэмээн хүлээж авсан бол түүнийгээ хэн нэгэнд дамжуулмаар санагддаг. Тэрхүү сэтгэл хөдлөл хийгээд баяр хөөр нэгээс нөгөөд дамжин явсаар 50 дахь хүн дээр очиход тэр хүн “Ямар талархмаар юм бэ.” хэмээн бодох аваас түүний хүртэх ач буян маш их байдаг. Хамгийн анх даган баясах сэтгэлийг үүсгэсэн хүний эдлэх ач буян хэмэвээс бүр ч зах хязгааргүй юм. Энэ бол та бидний сайн мэдэх “Сургаал 50 дамжсан тухай” хэмээх сургаал билээ.

Харин энэхүү “Даган баясах” гэдэг үгэнд “Бусдын сайн сайхан үйлийг хараад, сэтгэлдээ баяр баяслыг мэдрэх.” гэсэн утга агуулагддаг.

Та бүхэн ч бас сайн сайхан үйл хийж буй хүнийг хараад эсвэл тийм зүйл сонсохоороо сэтгэл хөдөлдөг биз дээ.

Гамшигт өртсөн газар нутгийг сэргээхэд хүчин зүтгэж буй сайн дурын хүмүүс болон Ковид 19 тахлын улмаас нойр хоолоо умартан ажиллаж буй эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр харах бүртээ хүндэлж, бахархаж байгаа хүн олон байгаа байх.

Мөн өдөр тутамдаа хайхардаггүй байсан өчүүхэн зүйл сэтгэлд гэрэл татуулан аз жаргал, баяр хөөрийг авчрах нь ч бий.

Галт тэргэнд хоёр настай бяцхан охин зорчигч нэг бүртэй хүндэтгэлтэйгээр дөхөн очиж, толгой бөхийн мэндэлсэн тухай сониноос уншсан юм. Явж байгаа галт тэргэн дундуур нааш цааш яваад гэж буруушаах хүн нэг ч байгаагүй бөгөөд тэрхүү гэнэн ариухан дүр төрх л бүгдийн сэтгэлийг хөдөлгөж, галт тэргэн доторх уур амьсгал тэр чигтээ халуун дулаан болсон гэдэг.

Эрүүл мэндийн байгууллагын эмч, ажилтнууд ч бай, галт тэргэн доторх бяцхан охин ч бай, яг тийм гэгээлэг зүйлийг хараад бид бүхэн яагаад сэтгэл хөдлөн баярлаж, халуун дулаан уур амьсгалыг мэдрдэг юм бол?

Бяцхан охинтой адил хиргүй тунгалаг сэтгэл хийгээд эмнэлэгийн ажилтнуудтай адилхан зовсон хүнд туслах юмсан гэсэн сэтгэл бидэнд ч бас байдаг учраас тэр билээ. Бодитой үйл хөдөлгөөн хийгээгүй ч, сайн сайхан зүйлд сэтгэл хөдөлж баярласан бол та хэдийн тэр үйлд оролцож байна гэсэн үг. Харин тэрхүү сэтгэлээ хэрхэн бодит болгох вэ гэдгийг танд үлдээе.





Хүн талархаж чаддагийн учир

Хүн бүр өөр өөрийн гэсэн зан чанар, сэтгэлийн тэнхээ, хүч чадал, байр суурьтай байдаг учраас хийж чадах зүйл нь ч гэсэн харилцан адилгүй байдаг. Тийм учраас жишээ нь ямар ч хүн хамгийн шилдэг сайн дурын ажилтныг дуурайя гээд чадахгүй болов уу. Харин сэтгэл хөдлөл хийгээд баяр хөөрөө амьдрах эрч хүч болгон хувиргаж, гайхамшигтай сайхан зүйлтэй учирсан бол “Ямар сайхан юм бэ” гэж талархаж чаддаг нь зөвхөн хүнд байдаг онцгой мэдрэмж гэдэг.

Гэвч сайтар бодоод үзвэл хүнээс бусад ургамал, амьтад талархаж чадахгүй ч гэлээ өөр өөрсдийн үүргээ гүйцэтгэнгээ агуу байгаль дэлхийн зохиолдлогооны дагуу амьдарч байдаг. Зөвхөн хүн л зүрх сэтгэлтэй атлаа орчлонгийн жам ёсыг умартан хар муу санаа, уур бухимдал, хүсэл шуналдаа төөрөлдсөний улмаас заримдаа зовж шаналан амьдардаг. Өөрөөр хэлбэл эсрэгээрээ хүн талархах сэтгэлтэй байна гэдэг нь агуу байгаль дэлхийн жам ёсны дагуу амьдарч байна гэсэн үг билээ.

Бид бүхэн сэтгэл амар амгалан, гэр бүл, нийгэмд хүмүүстэй эв эетэй амьдрахын тулд үргэлж “Баярлалаа.” хэмээн талархаж чаддаг байх л хамгийн чухал.

Азаар бид ямар ч зүйлийг “Талархаад баршгүй”, “Ямар гоё юм бэ” хэмээн хүлээж авснаар жинхэнэ сэтгэлийн амар амгаланг олж авч чадна гэдгийг мэддэг. Тийнхүү мөнгө, байр суурь байна уу үгүй юү гэдгээс үл хамааран үргэлж аз жаргалыг мэдэрч чадах хүнлэг хүн болохын төлөө бид бурханы зам мөрийг хэрэгжүүлж байгаа.

Тэрхүү баяр хөөр, талархах сэтгэлийг товчоор илэрхийлсэн буддын Данмапада судрын нэгэн мөр бий. “Хэзээ нэгэн цагт үхэлтэй тулгарах хэдий ч, Хүмүүн заяаг олохуяа бэрх, Одоо байгаа амь насандаа талархаж явбал зохимуй.” Хүний хувьд амь насыг олж, одоо энд амьдарч байна гэдэг нь жинхэнэ аж жаргал билээ. Тэр баярлаж талархсан сэтгэлээ “Сургаал 50 дамжсан тухай” сургаал шиг байгаагаар нь дамжуулаад байвал аз жаргал түгэн дэлгэрэх болно.

«Косей» 2020 оны 11 дугаар сарын дугаар



Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

«Оройн Дээд Цагаан Лянхуа Судар»

Номыг номлогчийн эрдэм буяныг өгүүлэх 19 дүгээр бүлэг

Зургаан мэдрэхүй ариусах эрдэм буян

Өмнөх “Даган баясахуйн эрдэм буяныг өгүүлэх 18 дугаар бүлэг”-ийн төгсгөл хэсэгт ч гэсэн гарсанчлан уг бүлэгт номын багшийн таван үйл (Сургаалыг хүлээн авах, унших, цээжээр унших, тайлбарлах, бичиж буулгах)-ийг идэвх зүтгэлтэйгээр хэрэгжүүлэгч хүний нүд, чих, хамар, хэл, бие, сэтгэл (Зургаан мэдрэхүй)-ээрээ эдлэх ач буяны тухай нарийн тодорхой айлдсан. Нилээд хэлбэрт баригдсан мэт илэрхийлэл нь орчин үеийн хүмүүст хачирхалтай санагдаж магадгүй. Гэвч бид бүхэн түүний цаадахь жинхэнэ үнэнийг л олж авах нь чухал гэж бодож байна.

Бодисадвагийн дөрвөн түйтгэргүй

Шагжамүни бурхан зургаан мэдрэхүй ариусах ач буяны хамгийн эхэнд нь нүдний тухай айлджээ. “Энэхүү Цагаан Лянхуа Судрын сургаалыг түйтгэргүй сэтгэлээр номлосугай.” хэмээх нэгэн мөр бий.

Энэ нь эртнээс “Бодисадвагийн дөрвөн түйтгэргүй” хэмээн хүндлэгдэн ирсэн сургаал билээ. Өөрөөр хэлбэл “Юунаас ч айж эмээлгүй, итгэж буй сургаалаа айлдан түгээх итгэл төгс байдал”-ыг хэлнэ. Энэ бол хожмын ертөнцөд Цагаан Лянхуа Судрыг түгээн дэлгэрүүлэх бодисадвагийн хамгийн эрхэм чухал эрдэм оюун гэж хэлж болно.

Нэгдүгээрт “Бүгдийг тогтоон, үл мартаж чадвар” хэмээх ба өөрийн сонссон бүхий л сургаалыг ягштал тогтоон авч, эс мартваас хэнд ч сургаалыг айлдсан айж эмээх зүйл байхгүй гэсэн үг.

Хоёрдугаарт, “Номын эмийг төгс мэдэх чадвар” хэмээх ба хүн нэг бүрийн ойлгох чадвар, сэтгэл санааны ялгааг сайтар мэдэж, хүн тус бүрт тохирсон сургаалаар анагааж чадвал юунд ч санаа зоволгүйгээр сургаалыг айлдаж чадна гэсэн үг.

Гуравдугаарт, “Асуултанд сайтар хариулах чадвар” хэмээх ба ямар ч асуулт хийгээд эсэргүүцэлтэй тулгарсан, жинхэнэ үнэний дагуу дэс дараатай, ямар ч хүнд ойлгомжтой хариулах аваас ямар ч асуудалгүйгээр сургаалыг айлдаж чадна.

Дөрөвдүгээрт, “Эргэлзээ тээнэгэлзээг арилгах чадвар” хэмээх ба хамаг амьтныг ялгалгүй аврах гэсэн Бурханы их нигүүлсэл лугаа сэтгэлээр, эргэлзэж, үл итгэсэн асуултад “Бурханы үнэн сэтгэл энэ билээ.” гэж шийдэмгийгээр хэлж чаддаг байх аваас ямар ч хүнээс айж эмээхгүй сургаалыг айлдаж чадна.

Ингээд харахаар бусдад сургаалыг түгээнэ гэдэг үнэхээр амар зүйл биш гэж зүрхшээх хүн бий л байх. Гэвч тэгж болохгүй. Дээрх өгүүлсэн чадварууд нь ном номлогч хүний ирээдүйн зорилго бөгөөд бүгдийг нь эзэмших юм бол их бодисадва болно гэсэн үг.

Тэрхүү их бодисадвагийн хувьд ч анхнаасаа тийм байсан гэсэн үг биш. Урт удаан сар жил дамжин уйгагүй хичээн зүтгэж, маш олон сорилт, алдаа оноог даван туулж байж ийм түвшинд хүрсэн байдаг.





Тиймээс бодисадвагийн зам мөрийг хэрэгжүүлж буй бид бүхэн энэхүү дөрвөн хүсэл, зорилгыг үргэлж цээжиндээ хадгалж, сэтгэлдээ баримталж, сургаалыг түгээн дэлгэрүүлэхэд болох юм. Хэрэв хэцүү асуудалтай тулгарч, хариулж үл мэдэх асуулт асуувал шууд “Үүнд хариулахад миний мэдлэг хүрэхгүй тул сайтар шалгаад, зохих хүнээс асуучихаад эргээд мэдэгдье.” гэж хариулах ёстой бөгөөд худлаа аргацаан өнгөрүүлж хэрхэвч болохгүй. Ингэж хариулах нь сургаал номлогчийн үнэ цэнийг унагах зүйл бус, харин эсрэгээрээ сонсож буй хүний итгэлийг улам төрүүлэх үр дүнтэй.

Ертөнцийн хууль ч гэсэн Бурханы сургаалтай адил

Уг бүлэгт орхигдуулж үл болох дараах чухал бадаг гардаг. “Хэрвээр эгэл ахуйн бичиг ном хийгээд төрийг засах итгэл үгүүлэл ба амь зуух ажил үйлийг номловч бээр цөм үнэн номд нийцмүй.” Одоогийн хэл рүү хөрвүүлбэл “Тийм хүний өдөр тутмын амьдралын тухай сургаал болон нийгэм ертөнцийг удирдан засах тухай яриа, ахуй амьдралын тухай зааварчилгаа нь хүртэл цаанаасаа зөв сургаал номд нийцсэн байдаг.” гэсэн үг.

Зөв сургаал ном гэдэг бол дан ганц сэтгэл санаа хийгээд хувь хүнээр хязгаарлагдахгүй ба зайлшгүй нийгэмд ч гэсэн түгэн дэлгэрдэг. Түүнчлэн ертөнцийн хуулийг бодитоор амилуулдаг юм. Тийм биш бол хүн төрөлхтнийг бүхэлд нь аварч эс чадна. Үүнийг л сэтгэлдээ хоногштол ойлгоосой гэж хүснэ.



Талархал ба тангараг

Манай байгууллагын хувьд 11 сар жилийн эцсийн сар болдог билээ. Энэ жил корона вирусны улмаас өмнөх жилүүдээс ялгаатай жил болж өнгөрсөн хэдий ч, олон зүйлийг шинээр олж нээсэн байх гэж бодож байна. Тэр дундаа “Юу хамгийн чухал вэ?” гэдгийг олж анзаарсан явдал хамгийн том нээлт байсан болов уу.


Нивано ерөнхийлөгчийн энэ сарын айлдвар “Талархаад баршгүй гэж хэлэх аз жаргал” гэсэн гарчигтай байсан. Энэ айлдвартаа Даган баясахуйн эрдэм буян 18-р бүлгийн “Сургаал 50 хүнд дамжих тухай” сургаалаас иш татан, сургаалыг сонсоод баярлах сэтгэл төрөхийн ач холбогдлыг тайлбарлажээ. Хүн бүр өөрт байгаа бурхан шиг сайн үйл хийх юмсан гэсэн сэтгэлээ олж анзаарч, түүний уг үндэс болох амь насыг хүртсэндээ баярлах сэтгэлээ хүмүүст дамжуулах нь чухал юм байна гэдгийг ойлгож авлаа.

Үүсгэн байгуулагчийн төрсөн өдрөөр дамжуулж, түүний амьдрал, үйл хэргийн талаар дахин эргэцүүлэн бодож, ач буянд нь талархаж, сургаал түгээн дэлгэрүүлэхээ тангараглах нь зүйтэй гэж бодож байна.

РКК Олон Улсын Хэлтсийн дарга
Саитоо Коичи



Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA
 TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633
 Email: sangha@rkhawaii.org URL: <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, USA
 TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA
 TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA
 POBox 33636, CA 90033, USA
 TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567
 Email: rk-la@sbcglobal.net URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

- Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**
- Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas**

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA
 POBox 778, Pacifica, CA 94044, USA
 TEL: 1-650-359-6951 Email: info@rksf.org URL: <http://www.rksf.org>

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

- Rissho Kosei-kai of Sacramento**
- Rissho Kosei-kai of San Jose**

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA
 TEL: 1-212-867-5677 Email: rkny39@gmail.com URL: <http://rk-ny.org>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA
 TEL: 1-773-842-5654
 Email: murakami4838@aol.com URL: <http://rkchi.org>

Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA
 POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA
 TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303
 Email: rkokdc@gmail.com URL: <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago St. #809 Denver, CO 80204, USA
 TEL: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA
 URL: <http://www.rkina-dayton.com>

The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA
 TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-269-4567
 Email: dharmasa@rksabuddhistcenter.org
 URL: <http://rksabuddhistcenter.org>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA
 (Mail) POBox 692148, San Antonio, TX 78249, USA
 TEL: 1-210-558-4430 FAX: 1-210-696-7745
 Email: dharmasanantonio@gmail.com
 URL: <http://www.rkina.org/sanantonio.html>

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA
 TEL: 1-253-945-0024 Email: rkseattlewashington@gmail.com
 URL: <http://buddhistlearningcenter.org>

Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil
 TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377
 Email: risho@rkk.org.br URL: <http://www.rkk.org.br>

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP, CEP 08730-000, Brasil

在家佛教韓國立正佼成會

〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

在家佛教韓國立正佼成會釜山支部

〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

社團法人在家佛教立正佼成會

台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

台南市在家佛教立正佼成會

台灣台南市崇明 23 街 45 號
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488
Email: kosekaitainan@gmail.com

Rissho Kosei-kai South Asia Division

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road, Rumpur, Gaya-823001,
Bihar, India

Rissho Kosei-kai of Patna Dharma Center

Please contact Rissho Kosei-kai of Kolkata

Rissho Kosei-kai of Central Delhi

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Singapore

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai of Phnom Penh

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo,
Phnom Penh, Cambodia

RKISA Rissho Kosei-kai International of South Asia

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Bangkok

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairissho@gmail.com

Rissho Kosei Dharma Foundation

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Please contact RiKISA

Rissho Kosei-kai Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
TEL/FAX: 880-31-626575

Rissho Kosei-kai Mayani

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Damdama

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Satbaria

Village: Satbaria Bepari Para, Chandanaih, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Chendhirpuni,

Village: Chendhirpuni, P.O.: Adhunogar, P.S.: Lohagara, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai Raozan

Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Laksham

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

Rissho Kosei-kai Dhaka

408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

Please contact Rissho Kosei-kai Bangladesh

Rissho Kosei-kai Patiya**Rissho Kosei-kai Ramu****Rissho Kosei-kai Aburkhiln****Buddiyskiy khram "Lotos"**

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia
TEL: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

Rissho Kosei-kai Friends in Shanghai**Rissho Kosei-kai of Ulaanbaatar**

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoro-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia
TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Erdenet

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29, 00184 Roma, Italia
TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

Please contact Rissho Kosei-kai di Rome

Rissho Kosei-kai of Paris**Rissho Kosei-kai of Venezia****Rissho Kosei-kai of the UK**

29 Ashbourne Road, London W5 3ED, UK
TEL: 44-20-8933-3247 Email: info@rkuk.org URL: <https://www.rkuk.org>
Facebook: <https://www.facebook.com/RKUnitedKingdom>
Twitter: https://twitter.com/rkuk_official
Instagram: https://www.instagram.com/rkuk_official

Rissho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)

166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <http://www.abc-rk.org>